



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/596.

Улаанбаатар хот

Нийслэлийн ерөнхий боловсролын 141
дүгээр сургуулийн эргэлтийн бус хөрөнгийг
данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэг, 4 дүгээр зүйлийн 4.6, 4.8 дахь хэсэг, Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Үндсэн хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2024 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 12 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй 30,056,819.00 (гучин сая тавин зургаан мянга найман зуун арван ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 141 дүгээр сургууль (Т.Баасанцэцэг)-д зөвшөөрсүгэй.

2.Данснаас хасагдаж буй 1 нэр төрлийн 30,056,819.00 (гучин сая тавин зургаан мянга найман зуун арван ес) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгахыг Нийслэлийн ерөнхий боловсролын 141 дүгээр сургууль (Т.Баасанцэцэг)-д үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Г.Тэмүүжин)-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



В.ОЮУМАА

1150501760

Нийслэлийн Өмчийн харилцаа, гүйцэтгэл, дүгээр сэдвийн өдрийн 4/350 дугаар тушаал

Байгууллагын нэр: Нийслэлийн ерөнхий боловсролын 141 дүгээр сургууль

[illegible]